



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/45

Биндэр сум

Сумын Засаг даргын нэрэмжит
гамшгаас хамгаалах бэлэн байдлын
үзлэгийг зохион явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Улсын онцгой комиссын 2025 оны “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” 01 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2025 оны А/136 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын урьдчилсан үзлэгийг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах удирдамжид заагдсан чиглэлээр бэлтгэлийг хангаж үзлэгт хамрагдахыг сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумын мэргэжлийн ангийн дарга (М.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН